

МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ЭРХЛЭГЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Аж ахуйн нэгжид:

- Биеийн халуун үзэх
- Ам, нүүрний хаалт зүүх
- Малгай, хормогч, бээлий өмсөх
- Хүн хооронд 1.5-2 метрийн зай барих
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байршуулах
- Агааржуулагч ажиллуулах, агаар сэлгэлт тогтмол хийх
- Бохирдсон хормогч, ханцуйвч эд зүйлсийг зориулалтын шингэнээр тогтмол угааж цэвэрлэх
- Өрөөн дэх бүх хатуу гадаргууг 1л усанд 25мл белизна хийсэн уусмалаар өдөрт 2-оос доошгүй удаа халдваргүйжүүлэх
- Сард 1 удаа мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх
- Халдвар судлагч, хүнсний технологич, эрүүл ахуйчийн бүрэлдэхүүнтэй багийг урьдчилан томилон, халдвар эсэргүүцэх төлөвлөгөөтэй байх
- Халдвар хамгааллын хяналт тавих хүн ажиллуулах
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх
- Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг ил тод байршуулах
- Халуурах, ханиах, цээжээр өвдөх зэрэг шинж тэмдэг илэрвэл 119, 80086829 дугаарт хандах

Мах бэлтгэгч, худалдагч нарт:

- Нойтон сальфетка, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчтэй байх
- Махны мод, хутга, ирлэгч зэргийг бусадтай сольж хэрэглэхгүй байх
- Бэлэн мөнгөөр тооцоо хийхгүй байх
- Бохир гараар ам, хамар, нүүрэндээ хүрэхгүй байх
- Ажлын хувцсаа тогтмол угааж, цэвэрлэх, хоорондоо солихгүй байх

БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Ачаа тээврийн байгууллагад:

- Өглөө бүр ажилтнуудын биеийн халуун үзэж тэмдэглэх
- Ажлын байрыг өдөрт 2 удаа тогтмол цэвэрлэх
- Хана, шал зэрэг хатуу гадаргууг 1л усанд 25мл белизна хийж халдваргүйжүүлэх
- Агаар сэлгэлт хийх

- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байршуулах
- Ачаа, тээшийг зайтай байрлуулах
- Агуулахын ажилчид тусгай хувцас өмсөх, дараа нь халдваргүйжүүлэх
- Агуулахын ачаа, барааг халдваргүйжүүлэх
- Нэг дор олуулаа сууж хооллохгүй байх

Хүргэлтийн ажилтанд:

- Амны хаалт зүүх
- Бээлий өмсөх
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч тогтмол хэрэглэх
- Жолооны хүрд, шалавч, бариул зэрэг хатуу гадаргууг арчиж цэвэрлэх
- Төлбөр, тооцоог аль болох карт болон цахимаар хийх
- Хүн хооронд 1.5-2 метр зай барих

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, СЭТГҮҮЛЧ, ЗУРАГЛААЧ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

- Цахим болон зайнаас ажиллах
- Амны хаалт зүүх
- Хүнтэй 1-1,5 метрийн зайнаас харьцах
- Иштэй микрофонд нэг удаагийн уут хэрэглэх эсвэл спиртэн суурьтай уусмалаар арчих
- Бээлий өмсөх
- Мэдээ, сурвалжлагад 2 хүн явуулах
- Аль болох хүн багатай газар ажиллах
- Албан байгууллага болон гудамж талбайд аль болох ярилцлага хийхгүй байх, хийсэн тохиолдолд ярилцлагын дараа амны хаалтаа солих
- Компьютер, утас, камер, тоног төхөөрөмжийг 2 цаг тутамд сайтар арчиж цэвэрлэх
- Студи, өрөө, тасалгааг өдөрт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх
- Гараа сайтар савандаж угаах (гар ариутгагч авч явах)

ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЛЭГЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

- Амны хаалт зүүх
- Биеийн халуун үзэх
- Хүн хооронд 1.5-2 метрийн зай барих
- Гараа сайтар савандаж угаах
- Нойтон сальфетка, спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгчтэй байх

- Бээлий, нүдний шил хэрэглэх
- Бохир гараар ам, хамар, нүүрэндээ хүрэхгүй байх
- Машин, техник хэрэгслийн хүрд, бариул зэрэг хүний гар их хүрдэг хэсгийг 1л усанд 25мл белизна хийж халдваргүйжүүлэх
- Ажлын хувцсаа тогтмол угааж, цэвэрлэх
- Алчуур, хувцас, хөнжил, гудас зэргийг наранд тавих
- Ус, ундаа ам дамжуулан хэрэглэхгүй, өөрийн усны савтай байх
- Тамхи дамжуулан татахгүй байх
- Шүлсээ ил задгай хаяхгүй байх
- Халуурах, ханиах, цээжээр өвдөх зэрэг шинж тэмдэг илэрвэл 119, 80086829 дугаарт хандах

УУЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Байгууллагад:

- Биеийн халууныг өглөө бүр хэмжиж, тэмдэглэх
- Сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөөтэй байх
- Сэжигтэй тохиолдлыг тусгаарлах 3-4 хүний бүрэлдэхүүнтэй багийг урьдчилан томилох
- Ковид-19-ийн тухай мэдээлэл тогтмол өгөх
- Гар угаах нөхцөлөөр хангах
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байршуулах
- Сүү, цагаан идээ, жимс ногоо зэрэг шим тэжээлтэй хоол хүнсээр хангах
- Хэт ачаалалтай ажиллуулахгүй байх, эрт амраах
- Ажилчдыг цөөн тоогоор байрлуулах
- 1,5-2 метрийн зай барих
- Ажилчдын байранд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт тогтмол хийх
- Хоолны газар, ариун цэвэр, хувцас солих өрөө, спорт заал, халуун усны газрыг өдөрт 2-оос доошгүй удаа цэвэрлэж, 1 литр усанд 25мл белизна (хлор агуулсан бодис) хийсэн уусмалаар халдваргүйжүүлэх, агаар сэлгэлт хийх
- Халуурах, ханиах, цээжээр өвдөх зэрэг шинж тэмдэг илэрвэл 119, 80086829 дугаарт хандах

Ажилчдад:

- Амны хаалт зүүх
- Ажлын хувцсаа бүрэн өмсөх

- Хувцсаа бусадтай сольж өмсөхгүй байх
- Гараа савандаж угаах, халдваргүйжүүлэх
- Ам, хамар, нүүрэндээ хүрэхгүй байх
- Хүн хооронд 2 метрийн зай барих
- Гар станц, ажлын багаж хэрэгслийг дамжуулж хэрэглэхдээ халдваргүйжүүлэх
- Цагаан хэрэглэл, алчуур, хөнжил, гудас, хувцас хэрэгслийг наранд тавих
- Шүлсээ ил задгай хаяхгүй байх
- Тамхи дамжуулж татахгүй байх

ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР, ХУДАЛДААНЫ ТӨВД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Байгууллагад:

- Өглөө бүр ажилтнуудын биеийн халуун үзэж тэмдэглэх
- Хүн хоорондын зай барих, тэмдэглэгээ хийх
- Лангуу, тэрэг, сагс, хаалга, хөргөгчний бариул, хүнсний хавчаар зэрэг хатуу гадаргууг 1 литр усанд 25мл белизна (хлор агуулсан бодис) хийсэн уусмалаар өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэж халдваргүйжүүлэх
- Карт уншигч пос машиныг спиртэн суурьтай уусмалаар арчих
- Жимс жимсгэнэ, цагаан идээ зэрэг шууд хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай байрлуулахгүй байх
- Амталгаат худалдаа хийхгүй байх
- Бээлий эсвэл хүнсний хавчаар хэрэглэн иргэдэд үйлчлэх
- Сав,баглаа, боодлыг чийгтэй алчуураар арчих
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байршуулах
- Агаар сэлгэлт тогтмол хийх
- Белизнагийн уусмалаар тавцан, сандал, цахилгаан шатны бариул, шал зэрэг хатуу гадаргууг өдөрт 3-аас доошгүй удаа арчих
- Ариун цэврийн өрөөнд гар угаах саван, сальфетка байрлуулах
- Бие засах газрыг өдөрт 3-аас доошгүй удаа цэвэрлэж халдваргүйжүүлэх (жавелин, хлорсепт)
- Хог хаягдлыг тухай бүрт нь зайлуулах

Албан хаагчдад:

- Амны эсвэл нүүрний хаалт зүүх
- Бээлий өмсөх
- Гараа сайтар угаах

- Ковид-19-ийн талаар мэдээлэлтэй байх
- Халуурах, ханиах, цээжээр өвдөх зэрэг шинж тэмдэг илэрвэл 119, 80086829 дугаарт хандах

АЧАА ТЭЭВРИЙН ЖОЛООЧ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

- Амны хаалт зүүх
- Бээлий өмсөх
- Өдөрт 3 удаа биеийн халуунаа хэмжиж тэмдэглэх
- Тархвар зүйн асуумж, судалгааг үнэн зөв бөглөх
- Гараа сайтар савандаж угаах
- Гараа ам, хамар, нүүрэндээ хүргэхгүй байх
- Давс, нимбэг, содатай бүлээн усаар ам, хоолойгоо зайлах
- Халуун бүлээн шингэн ойр ойрхон уух, тагтай аяга хэрэглэх
- Олон цагаар жолоо барихгүй байх
- 2 метрээс дотогш зайд бусадтай харьцахгүй байх
- Шүлсээ ил задгай хаяхгүй байх
- Машиндаа зорчигч суулгахгүй байх
- Машинаасаа аль болох буухгүй байх
- Аяга, халбагаа халуун усаар сайтар угаах
- Хувийн ариун цэврийн хэрэгслээ өөр хүнд хэрэглүүлэхгүй байх,
- Ус, саван, алчуур, гар ариутгагч, нойтон салфетка байнга авч явах
- Кабины дотор тал, хаалганы бариул, жолооны хүрд, араа зэрэг гар их хүрдэг хэсгийг өдөрт 2-оос доошгүй удаа нойтон салфетка, чийгтэй алчуураар цэвэрлэх
- 2 цаг тутам цонхоо онгойлгож, агаар сэлгэлт хийх
- Халуурах, ханиах, бөөлжих, суулгах, булчин өвдөх зэрэг шинж тэмдэг илэрвэл 119, 80086829 утсаар зөвлөгөө авах

- Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах
- Хуваарилсан шатахуун түгээх газраар үйлчлүүлэх Хилийн боомтод:
- Нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг нэмэлт гэрчилгээ шаардахгүй эхэлж нэвтрүүлэх
- Тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнийг халдваргүйжүүлэх
- Сэжигтэй тохиолдлыг тусгаарлах
- Тусгаарлах байр түгжээтэй хаалга, цонхтой байх
- Тусгаарлагдсан иргэнд зориулсан бие засах газартай байх
- Спиртэн суурьтай гар ариутгагч, халдваргүйжүүлэх бодисыг зааврын дагуу хэрэглэх
- Ариун цэврийн байгууламж, тоног төхөөрөмж, хангамжийг байлгах. Түүний дотор гарын эрүүл ахуй, ачааны машины дугуйг халдваргүйжүүлэх үйлчилгээ байх

ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

- Ажилчдын биеийн халууныг үзэж нэвтрүүлэх
- Ажлын малгай, хувцас, гутал, улавч өмсөх
- Маск, тусгай амны хаалт зүүх
- Хүнтэй 1.5-2 метрийн зайнаас харьцах
- Хүнс, хоол үйлдвэрлэх, худалдах зэрэг шат дамжлага бүрт спиртэн суурьтай гар ариутгагч байршуулж хэрэглэх
- Нэг удаагийн бээлий хэрэглэж тайлах бүрт гараа заавал савандаж угаах
- Хоол бэлтгэх өрөө, талбай, хатуу гадаргууг ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор 2 цаг тутам цэвэрлэх
- Аяга, таваг, халбага, сэрээг ахуйн хэрэглээний халдваргүйжүүлэх бодисоор сайтар угаах
- Түүхий, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу хадгалах
- Хүргэлтийн үйлчилгээний ажилтан амны хаалт зүүж, бээлий өмсөх
- Ажилчдад коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэг, урьдчилан сэргийлэлтийн талаар мэдээлэл өгөх
- Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг ил тод байршуулах
- Ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах
- Хоол хүнс бэлтгэх, хадгалах өрөөг шавьж мэрэгчээс хамгаалах

Аж ахуйн нэгж, байгууллагад өгөх зөвлөмж

Ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, анхаарал халамж тавих, дархлааг дэмжих нь Коронавируст халдварт өртөх эрсдэлийг бууруулна.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД:

- Албан хаагчдын биеийн халууныг өглөө бүр биеийн халууныг үзэж, өвчний шинж тэмдэг илэрвэл гэрт нь буцаах
- Өвчлөл гарсан бүс нутагт томилолтоор явуулахгүй байх
- Үйлчилгээг цахимжуулан хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх
- Санал хүсэлт, өргөдлийг утсаар болон цахимаар авах
- Хурал уулзалтыг богино цагаар, цөөн хүнтэй хийх
- Хурлын үеэр өрөөнд цэвэр агаар оруулах
- Хурлын дараа хатуу гадаргууг сайтар цэвэрлэх
- Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч байлгах
- Микрофоныг спиртэн суурьтай уусмалаар арчих эсвэл нэг удаагийн уут хэрэглэх
- Цахилгаан шатны товчлуур, явган болон урсдаг шат, хаалганы бариул, компьютер, утас зэргийг өдөрт 2-оос доошгүй удаа сайтар арчиж цэвэрлэх
- Халуун аарц, чацаргана, зөгийн балтай ус, цайгаар ажилчиддаа өгөх
- Хоолны газарт ажилчдыг цөөн тоогоор ээлжлэн үйлчлэх
- Ажлын байрны дарамт, стресс үүсгэхгүй, дасгал хөдөлгөөн хийх
- Ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг амны хаалтаар хангахад дэмжлэг үзүүлэх
- Урьдчилан сэргийлэх зөвлөмжийг албан тасалгаанд ил тод байрлуулах
- Ариун цэврийн өрөөнд саван, гар халдваргүйжүүлэгч, гарын цаас байлгах
- Ариун цэврийн өрөөнд чийгтэй цэвэрлэгээг 4-өөс доошгүй удаа хийх

Ажилчин, албан хаагчдад:

- Халуун бүлээн шингэн ойр ойрхон уух, тагтай аяга хэрэглэх
- Давс, нимбэг, содтой бүлээн усаар ам, хоолойг зайлах
- 1-5 давхарт цахилгаан шат ашиглахгүй байх
- Аяга, халбагаа халуун усаар сайтар угаах

- Гараа сайтар савандаж угаах
- Нүд, ам, хамартаа гар хүрэхгүй байх
- Амны хаалт зүүх
- Аль болох бэлэн мөнгөтэй харьцахгүй байх
- Шүлсээ хаяхгүй байх